

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД БОДЛОГО: УЛАМЖЛАЛ БА ШИНЭЧЛЭЛ

*Ц.Мөнх-Оргил**

Монгол Улсын Их Хурлаас өнгөрсөн онд баталсан Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт манай гадаад бодлогын чиглэлээр ирэх 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, авах алхмуудыг тодорхойлон заасан билээ.

Уг хөтөлбөрт “Монгол Улсын олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлэн, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалын зарчмуудыг улс орны болон дэлхий дахины шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн, бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхитэй явуулж, өөрийн орны язгуур эрх ашиг, түүний дотор иргэд, аж ахуйн нэгжүүдийн хууль ёсны эрх ашгийг гадаадад тууштай хамгаалж байх зарчмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлнэ” гэж заасан. Үүнийг товчхон тайлбарлавал уламжлал, шинэчлэлийг хослуулна гэсэн үг юм. Уламжлал гэдэг нь Монгол Улсын гадаад бодлого залгамж шинжтэй гэдгийг хэлж буй бөгөөд шинэчлэл гэдэг нь гадаад бодлогодоо өөрийн орны болон олон улсын харилцааны хөгжлийн шинэ нөхцөл байдлыг тусган, үйл ажиллагаагаа уян хатан явуулна гэсэн утгыг агуулж байгаа юм.

“Хүйтэн дайн” төгсгөл болж, дэлхийн улс гүрнүүдийн олонхи нь хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг эрхэмлэн ардчилал, хүний эрхийг дээдлэх, тулгамдсан дэлхий дахины шинжтэй асуудлуудыг хамтын хүчээр шийдвэрлэх хүсэл эрмэлзэл давамгайлах болсон энэ он жилүүд Монгол Улсын гадаад бодлого, гадаад харилцаанд онцгой байр суурь эзэлж байна. Тухайн үеийн хоёр туйлт олон улсын харилцаанаас улбаатай үзэл суртлын хүлээс тайлагдаж эхэлсэн 1980, 1990-ээд оны зааг дээр тус оронд ардчилсан хөдөлгөөн өрнөж, улмаар Монгол Улс дэлхий нийтийн хөгжил дэвшлийн нийтлэг зам, голдиролд эргэлт буцалтгүй орсон.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль, Гадаад бодлогын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал зэрэг тулгуур баримт бичгүүд орчин цагийн Монгол төрийн гадаад бодлогын эрх зүйн үндсийг тавьснаараа зарчмын ач холбогдолтой болсон юм. Монгол Улсын Засгийн газар нь эдгээр баримт бичгийн үг үсэг, үзэл санааны дагуу дэлхийн улс орнуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд

*Ц.Мөнх-Оргил - УИХ-ын гишүүн, Гадаад хэргийн сайд

чиглэсэн нээлттэй, идэвхтэй, олон тулгуурт гадаад бодлого явуулж Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн нэн таатай гадаад орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллаж байна.

Дээрхи баримт бичгүүдэд гадаад бодлогын зорилго, чиглэл, үндсэн зарчмуудыг тодорхойлоод зогсоогүй, гадаад бодлогын “гал зуух” хэмээгддэг гадаад бодлогын шийдвэр гаргах арга механизмын тухай мөн тусгасан. Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу гадаад бодлогын шийдвэр гаргах субъектуудад Засгийн газрын зэрэгцээ Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөл ордог. Энэхүү тогтоцын аль ч түвшинд гарсан хууль тогтоомж, шийдвэр, чиглэл нь бусад түвшингийн хэмжээнд гарсан шийдвэртэйгээ нэгдмэл цогц шинж чанарыг агуулж байдаг. Гадаад бодлогын ийм нэгдмэл цогц шинж чанарыг хангахад Монгол Улсаас гадаадтай харилцах гол чиглэл, асуудлуудыг дагнан эрхэлдэг, тус орны гадаад бодлогыг боловсруулж, хэрэгжүүлдэг төрийн захиргааны төв байгууллага болох Гадаад хэргийн яам гол үүрэг гүйцэтгэдэг нь мэдээж. Ийм ч учраас манай гадаад бодлого тухайн үеийн нөхцөл байдлын зарим онцлогыг харгалзан тусгахын сацуу уламжлал, залгамж чанараа хэзээ ямагт хадгалсаар ирсэн онцлогтой. Түүнчлэн гадаад бодлогын аливаа шийдвэр гаргах үйл явцад улс төрийн намууд, тодорхой ашиг сонирхлын бүлгүүд, төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зохих нөлөө үзүүлж, үүрэг гүйцэтгэж байгааг үгүйсгэх аргагүй. Энэ бол ардчилсан нийгмийн хэрэгцээ шаардлага мөн. Энэ нь “Гадаад бодлогын шийдвэр гаргах соёл”-д суралцах асуудлыг утга дэвшүүлэн тавьж байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, гадаад бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд оролцон тоглогчдын тоо ихээхэн нэмэгдсэн гэсэн үг. Ганц жишээ дурьдахад өдгөө манай оронд янз бүрийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг 2400 орчим төрийн бус байгууллага бий болсон бөгөөд эдгээрээс 130 гаруй нь гадаад орнуудад өөрсдийн түнштэй болж, олон улсын байгууллагатай харилцаа тогтоон ажиллаж байна. Энэ нь бидний харгалзан үзэх л ёстой асуудлын нэг юм.

Цаашилбал, иргэд, хувийн хэвшлийнхэн, аж ахуй нэгжийн хууль ёсны эрх ашгийг хилийн чанадад хамгаалах явдал бидний бас нэг чухал зорилт байх болно. Дотоодын нийт бүтээгдэхүүнд хувийн хэвшил 1990 онд дөнгөж 4%-ийг эзэлж байсан бол эдүгээ 80 гаруй хувьд хүрлээ. Өнөөдөр манай улсад 17 мянга гаруй үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагууд, түүний дотор 8 мянга гаруй пүүс компани ажиллаж, гадаад орнуудын түншүүдтэйгээ шууд харилцаж, гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны нэн чухал хэсгийг нуруундаа үүрч явна.

Хувийн хэвшилд гадаадад зах зээл олох, тэдэнд олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд тусламж дэмжлэг үзүүлэх явдал чухал байна.

Шинэчлэлийн тухай ярихад хүргэж буй өөр нэг сэдэв бол даяаршил мөн. XXI зууны эхэнд дэлхий нийтийн буюу бүс нутгийн чанартай ямар ч асуудлыг нэг улс битгий хэл нэг хэсэг улс ч дангаар шийдэж чадахгүй нөхцөл байдал үүссэн билээ. Бүх зүйл харилцан уялдаа холбоотой болсон учраас аливаа асуудлыг бусдаас салангид шийдвэрлэх боломжгүй болжээ.

Дэлхий дахины шинжтэй энэ хандлага нь Монгол Улс шиг бага буурай эмзэг эдийн засагтай улсад, сайн муу хоёр талын нөлөө үзүүлж байгаа нь ойлгомжтой. Даяаршлын үйл явцыг бүрэлдүүлэгч гол хүчин зүйл болсон мэдээллийн технологийн хөгжил нь Монгол Улсын далайд гарцгүй байдлаас урган гарч буй сөрөг хүчин зүйлүүдийг саармагжуулахад ихээхэн нааштай нөлөөлж байна. Өнөөдөр бид кабелийн телевиз үзэж, дэлхийн аль ч өнцөг буланд амьдран суугаа ах дүү, анд нөхөлтэйгөө хоромхон зуур гар утсаар холбогдож, орчлон дэлхийн хэрэг явдлыг цаг алдалгүй мэддэг болов. Энэ бол даяаршлын үр шим яах аргагүй мөн. Бид дэлхийн аль ч хэсэгт өрнөж буй үйл явдлын тухай мэдээллийг интернет ашиглан дуртай үедээ авч байна. Түүнчлэн өнөөдөр мэдээллийн технологийн хөгжил дэлхийн аль ч улс орон, аж ахуйн нэгж, хувь хүмүүс мөнгөн гуйвуулгаа чөлөөтэй хийж, цахим худалдаагаар дуртай үедээ хэрэгцээт бараагаа олж авах боломж бүрдсэн нь даяаршлын бас нэг үр шим мөн бөгөөд үүнээс манай улс хувь хүртэх бүрэн боломжтой. Энэ талаар ч Засгийн газар гадаад бодлого, олон улсын үйл ажиллагаандаа тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Гэхдээ даяаршлын үйл явц нь тодорхой нөхцөл байдалд сөрөг үр дагаврыг өөртөө агуулж болзошгүйг үгүйсгэх аргагүй. Үйл явцыг залж чиглүүлэхгүй, зөнд нь тавибал даяаршлаас үүдэн зарим бага буурай орны үндэсний өөрийн гэсэн өвөрмөц дүр төрх, уламжлал, соёл, зан заншил алдагдаж, сөрөг нөлөөнд автаж болзошгүй юм. Түүнчлэн мөнгө угаах, эдийн засгийн гэмт хэрэг, хар тамхины наймаа, хууль бус зэвсгийн наймаа, улс гүрэн дамжсан гэмт хэрэг, халдварт өвчин зэрэг үйлдэл, сөрөг үзэгдэл хил хязгаараас үл хамааран олон улс гүрэнд нэвтэрч, тархах аюул ихсэж байна.

Эдгээр шинэ аюул заналын эсрэг улс орнуудын хүчин чармайлтад манай улс нэгдэн орж өөрийн хувь нэмрээ оруулах ёстой гэж үзэж байна.

Хүн төрөлхтний өмнө тулгараад байгаа бас нэг ноцтой асуудал бол байгалийн гамшигтай тэмцэх, түүнээс сэргийлэх, нэгэнт тохиосон

гамшгийн хор хохирлыг нэн даруй арилгах асуудал юм. Байгалийн ийм гамшгийн нэг нь өнгөрсөн оны 12-р сард Энэтхэгийн далайд болсон газар хөдлөлт бөгөөд уг газар хөдлөлтөөс үүссэн далайн их түрэлтээс /цунами/ шалтгаалан дэлхийн 12 оронд олон арван мянган хүн амь үрэгдэж, асар их хэмжээний эд материалын хохирол учирсан билээ. Далайгаас алслагдсан хэдий ч Монгол Улс, манай ард түмэн байгалийн энэхүү гамшигт нэрвэгдсэн улсуудад гүнээ харамсал илэрхийлэхийн сацуу эд материалын тусалцааг боломжийнхоо хирээр үзүүлж байна.

Том, жижиг бүх улсыг адилхан хамарч байгаа, дэлхий дахины шинжтэй асуудлын нэг бол олон улсын терроризмтэй тэмцэх явдал мөн. Террористуудаас 2001 оны 9-р сарын 11 -нд АНУ-д үйлдсэн аймшигт халдлага нь терроризмын эсрэг хийх тэмцэл бол дэлхийн нийтийн шинж чанартай, ноцтой асуудал гэдгийг харуулав. Энэ нь терроризмын эсрэг дэлхийн том, жижиг улс орнууд хамтран тэмцэх ёстой, энэ аюулыг зайлуулахад улс гүрэн бүр оролцох ёстой гэдгийг нотлов.

Манай бүс нутагт улс төрийн яриа хэлцээ идэвхтэй явагдаж, эдийн засгийн интеграци гүнзгийрч байгаа зэрэг нааштай хандлагын сацуу бүс нутгийн зарим хэсэгт террорист үйл ажиллагаа гарсаар байна. Дэлхийн нөлөө бүхий зарим төвөөс гаргасан судалгаанаас үзэхэд 2003 онд болсон террорист халдлагуудын 37 хувь нь Азид, 17 хувь нь Ойрхи Дорнодод зохион байгуулагджээ. Сингапурын нэг судалгааны хүрээлэнгээс гаргасан мэдээгээр бол Ази, Номхон далайн бүс нутагт 2003 онд 400 гаруй террорист халдлага гарсан байна. Ийм халдлагууд манай хөрш оронд ч гарсаар байна. Сүүлийн нэг жишээ бол өнгөрсөн оны 9-р сард ОХУ-ын Беслан хотод террористууд халдлага хийсний улмаас гэм зэмгүй энгийн олон иргэн, түүний дотор хэдэн зуун хүүхдийн амь нас хохирсон ноцтой үйлдэл гарч дэлхий дахиныг хирджийлгэн цочирдуулсан билээ. Үүнийг Монгол Улсын төр, засгаас шийдвэртэй буруушааж, амь үрэгдэгсдийн ар гэр болон хохирогсдод зохих хэмжээний хүмүүнлэгийн тусламж үзүүлсэн.

Монгол Улсын хувьд нэг талаас сүүлийн жилүүдэд манай гадаад харилцаа ихээхэн тэлж өргөжсөн, нөгөө талаас эдийн засгийн чадавхи сул дорой хэвээр байгаа нь олон улсын террорист үйл ажиллагаанд манайх өртөж болзошгүй хөрс дэвсгэрийг бий болгож байгааг тэмдэглэх ёстой. Гадаадад суугаа манай ДКТГ-уудын аюулгүй байдлыг бэхжүүлэх нь үүнтэй холбогдож нэг чухал зорилт болон тавигдаж байна. Олон улсын терроризмтэй тэмцэх нь угтаа өргөн цар хүрээтэй асуудал тул манай улсын иргэн бүр сонор сэрэмжтэй байх явдал ч чухал болж байна.

Терроризмтэй тэмцэхтэй холбогдсон өөр нэг асуудал бол сүүлийн үед эрчимтэй тархаж буй цахим /cyber/ терроризмын асуудал юм. Иймд харилцаа холбооны нууц алдагдуулахгүй байх, түүнийг баттай хамгаалалтанд авах тал дээр улсын хэмжээнд цахим терроризмийн эсрэг тодорхой арга хэмжээ авах шаардлага гарч байна. Үүнтэй уялдан манай холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, энэ асуудлаар улсын хэмжээнд нэгдсэн ойлголтонд хүрэх, судалгааны болоод зохион байгуулалтын дорвитой арга хэмжээ авах, энэ талаархи гадаад улс орнуудын хуримтлуулсан туршлагыг судалж, түүнийг өөрийн хөрс шороонд тохируулан бүтээлчээр хэрэглэх шаардлага гарч байна.

НҮБ, түүний төрөлжсөн болон салбар байгууллагуудтай хамтран ажиллах бидний бодлого хэвээрээ. Тэгэхдээ энд хэд хэдэн асуудлыг онцгойлон авч үзэх ёстой.

Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг олон улсын хэмжээнд эрх зүйн хувьд баталгаажуулах, Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын Ү бага хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар өмнөх жилүүдэд ажиллаж ирсэн шигээ бид өөрийн зүгээс тодорхой үйл ажиллагаа явуулах болно.

НҮБ-аас өмнө нь баталсан Мянганы хөгжлийн зорилтуудыг /МХЗ/ хэрэгжүүлэхэд гарсан ахиц, дэвшлийг хэлэлцэхээр дэлхийн улс гүрний удирдагчид Нью-Йорк хотноо 9 дүгээр сард хуран чуулна. Энэ чухал үйл явдалд бэлтгэх ажлын хүрээнд Монгол Улс МХЗ-ын хэрэгжилтийн явц байдлын тухай анхны үндэсний илтгэлээ бэлтгэн гаргаад байгаа бөгөөд эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхийн төлөө хөгжлийн хамтын ажиллагааны түншүүдтэйгээ нягт хамтран ажиллаж байна.

Дэлхийн улс орнуудын анхаарлыг ихэд татаж буй өөр нэг асуудал бол НҮБ-ын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт юм. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннаны санаачилгаар 2003 онд байгуулагдсан өндөр түвшний ажлын хэсэг НҮБ-ын өөрчлөлт, шинэчлэлтэй холбогдсон тусгай илтгэлийг бэлтгэж өнгөрсөн оны сүүлээр нийтэд мэдээлсэн бөгөөд шинэчлэлтийн талаар 101 санамжийг багтаасан уг илтгэл нь эдүгээ дэлхийн олон улс гүрний анхаарлыг татаж байгаа юм. Илтгэлд ялангуяа даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэг хүлээсэн НҮБ-ын гол байгууллага болох Аюулгүйн Зөвлөлийг өргөтгөхийг зөвлөмж болгосон бөгөөд уг илтгэлийн талаар зарим орон урьдчилан байр сууриа илэрхийлээд байна. Манай улс ч илтгэлийг нарийвчлан судалж, нийтэд мэдэгдэх шаардлага эдүгээ тулгарч байгаа юм. Монгол Улс НҮБ-ын бүрэн эрхт гишүүний хувьд

Аюулгүй Зөвлөл, Ерөнхий Ассамблей, төрөлжсөн байгууллагуудын өөрчлөлт шинэчлэлийн талаархи Ерөнхий нарийн бичгийн даргын хүчин чармайлтыг дэмжиж ажиллахын зэрэгцээ эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг хөгжиж байгаа, бага буурай орнуудын эрх ашигт аль болох нийцсэн байхаар явуулахыг зорих болно. Орчин үеийн олон улсын харилцааны тулгамдсан зорилтууд, ерөөс хүн төрөлхтний өмнө тулгарч буй дэлхий дахины шинжтэй асуудлыг шийдвэрлэхэд НҮБ голлох үүрэг гүйцэтгэж, өнөөгийн даяаршлыг урсгалаар нь тавих бус, харин түүнийг чиглүүлэн залах нэг гол хөшүүрэг байх ёстой гэж бид үзэж ирсэн. НҮБ энэ чухал зорилтоо биелүүлэхийн тулд өөрчлөгдөх ёстой гэж гишүүн орнууд үзэж байгаатай манай улс санал нэг байгаа. Бүр тодорхой яривал манай улс Аюулгүйн Зөвлөлийг шударга үндсэн дээр өргөтгөх, түүний байнгын болон байнгын бус гишүүдийн тоог хөгжиж буй болон хөгжингүй орнуудын зохистой төлөөллийг хангах замаар нэмэгдүүлэх нь чухал гэж үзэж байна.

Даяаршлын үйл явц хамгийн түргэн явагдаж буй бүс нутаг болох Зүүн Азид интеграцийн үйл явц эрчимтэй өрнөж байгааг танай сэтгүүлийн уншигчид мэднэ. Зүүн Азийн төр, засгийн тэргүүн нарын анхны уулзалт энэ онд Малайзид болох гэж байна. 2007 онд АПЕК-ийн гишүүнчлэлийн хоригийн хугацаа дуусахад Монгол Улс гишүүнээр элсэх зорилт бидэнд мөн тулгарч байгаа юм.

Олон улсын зах зээлийн боломжийг илүүтэй ашиглах, өндөр хөгжилтэй орнууд, тухайлбал АПЕК-ийн гишүүн орнуудын зах зээлд экспортлох бараа, бүтээгдэхүүнийг гаалийн татваргүй нийлүүлэх боломжийг эрэлхийлэн ажиллах, хоёр талын харилцааг худалдаа, эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын агуулгаар баяжуулж, тодорхой орнуудтай харилцах дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, худалдааны нэн тааламжтай хөнгөлөлт эдлэх нөхцлийг худалдааны түнш зарим оронд тавьж шийдвэрлүүлэн гадаад зах зээлийн хүрээнд тэлэх арга хэмжээ авна. Түүнчлэн Монгол Улс Зүүн Ази болон нийт Азийн хэмжээнд явагдаж байгаа олон талт үйл ажиллагаанд идэвхтэй оролцохын тулд Ази, Европын дээд хэмжээний уулзалтад /АСЕМ/ нэгдэх нь чухал гэж үзэж байна. Ялангуяа 2006 онд болох АСЕМ-ийн дээд хэмжээний уулзалтанд оролцохын тулд бид холбогдох улс орнуудтай идэвхтэй ажиллах шаардлага гарч байна.

Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн болон нийгмийн хөгжил нь дотоод, гадаадын хувийн хэвшлийн шууд хөрөнгө оруулалт, экспорт давамгайлсан худалдааны өсөлтөөс хамааралтайг иш үндэс

болгон худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тухай хэлэлцээр байгуулж, хэрэгжүүлэн ажиллах нь Зүүн Азийн интеграцид нэгдэн орох бодитой бололцоо нөхцлийг бүрэлдүүлнэ. Үүнтэй холбогдуулан Гадаад хэргийн яам нь тухайн асуудлыг шууд эрхэлдэг бусад яам газруудтай үйл ажиллагаагаа зохицуулж, цаашид идэвхтэй хамтран ажиллах замаар тэдний үйл ажиллагаанд зохих ёсны дэмжлэг туслалцаа үзүүлж байх болно.

Монгол Улс Зүүн хойд Ази болон Төв Азийн олон талт үйл явц, яриа хэлэлцээ, интеграцид үр ашигтай оролцож түүнд өөрийн хувь нэмрийг оруулах, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах, бүсийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах чиглэл баримтлана. Чингэхдээ бүс нутгийн аливаа маргаантай асуудлыг гагцхүү тайван замаар олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээний үндсэн дээр шийдвэрлэх ёстой гэж бид үздэг. Манай бүс нутгийн ээдрээтэй асуудлын нэг болох Солонгосын хойгийн асуудлын шийдлийг ч үүнд хамааруулдаг. Бид 6 талт яриа хэлэлцээг дэмжиж ирсэн. Энэ асуудлаарх яриа хэлэлцээ цаашид ч үргэлжиж, тодорхой үр дүнд хүрээсэй гэж манай Засгийн газар хүсэн хүлээж байна.

Бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд нэг болоод хоёрдугаар сувгийн аль алиныг ашиглах хэрэгтэй юм. АСЕАН-ы бүсийн Чуулга /АРФ/, Азид хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх асуудлаар болдог зөвлөлгөөн /СВМДА/, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/, Азид хамтран ажиллах яриа хэлэлцээ /АСД/-ний үйл ажиллагаа үүнд хамаарна. Мөн эрдэмтэн мэргэд, төрийн бус байгууллагуудын шугамаар бүс нутагт явагдаж байгаа уулзалт, яриа хэлцээнд ч боломжийн хэрээр бид оролцохыг бодолцох ёстой.

Манай гадаад бодлого болон олон улсын талбарт явуулдаг үйл ажиллагаанд бусад улс гүрэнтэй тогтоосон хоёр талт харилцаа, хамтын ажиллагаа нэн чухал байр суурь эзэлдэг нь мэдээж. Монгол Улс үндэсний аюулгүй байдал, хөгжлийн гадаад таатай орчинг бүрдүүлэх зорилгоо эрхэмлэн бусад улс гүрнүүдтэй тогтоосон хоёр талт найрсаг харилцааг бүх талаар өргөтгөн, даяаршилд нийцүүлэн хөгжүүлэх зорилт тавьж байна. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тодорхойлсон гадаад бодлогын зорилтууд ч энэ хүчин зүйлийг тооцсон. Гадаад хэргийн яам дунд хугацааны үйл ажиллагааны чиглэл гаргаж, голлох орнуудтай харилцах хөтөлбөрүүд боловсруулаад байна. Энэ бүхэн нь даяаршлын эрин үед Монгол Улсын гадаад бодлого, үйл ажиллагааг оновчтой, судалгаатай явуулах, алсыг харж тооцоход чиглэж байгаа

юм. Хоёр талын харилцааны үндэс суурь хэр бэхжинэ тэр хэмжээгээр манай орны аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн гадаад таатай орчин бүрдэх нь ойлгомжтой юм.

Манай хоёр хөрш ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн түншлэлийн харилцааг бүх талаар хөгжүүлэхийг бид зорьж байна. Хоёр хөрш орны хувьд Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд аль аль талаасаа өндөр, дээд хэмжээний дипломат үйл ажиллагааг идэвхтэй явуулахаар төлөвлөж байгаа. Дипломат ажиллагааны арга хэрэгслийн хувьд эдгээр айлчлалуудын гол зорилго нь иж бүрэн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд эдгээр улс оронтой улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн болон бусад салбарт бүх талын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэхийг зорино.

Гадаад бодлогын үзэл баримтлал, Эвслийн Засгийн газрын мөрийн хөтөлбөр зэрэг баримт бичгийн нэн чухал заалт нь АНУ, Япон, БНСУ, ХБНГУ зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлж, тэдний бодит сонирхлыг Монголд бий болгоход чиглэгдэж байгаа билээ. Цаашид бид эдгээр оронтой харилцах харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахаар ажиллана. Ийм хэлэлцээрүүд цаашдаа бүс нутгийг хамарсан өргөн хэмжээний чөлөөт бүсэд нэгдэн ороход эрх зүйн нөхцлийг бүрдүүлнэ гэдэг утгаараа ихээхэн чухал юм.

Ардчилал, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, зах зээлийн эдийн засгийн харилцааг хөгжүүлэх, терроризмын эсрэг тэмцэх зэрэг түгээмэл зарчимд тулгуурлан хөгжиж байгаа Монгол, Америкийн харилцаанд бид нэн чухал ач холбогдол өгч ирсэн. Өнгөрсөн оны дундуур Монгол Улсын Ерөнхийлөгчийн АНУ-д хийсэн айлчлалын үеэр байгуулсан Монгол, Америкийн Хамтарсан Мэдэгдэл хоёр орны харилцааны түвшинг томъёолон тодорхойлж, эрх зүйн үндэс суурийг нь бэхжүүлснээрээ чухал ач холбогдолтой болсныг энд зориуд тэмдэглэж байна. “Мянганы сорилтын сан”-д манай улс дахин шалгарсныг уншигч олон мэдэж байгаа. Энэ сангийн хүрээнд тусламж авах чиглэлээр ажиллах явдал Монгол, Америкийн хоёр талын харилцаанд ойрын үед хэрэгжүүлэхээр бидний тавих нэг чухал зорилт юм.

Япон улс бол Монгол Улсын гол хандивлагч орон гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Монголд ардчилал, зах зээлийн харилцаа өрнөн хөгжсөн 1990 оноос хойш манайд дэлхийн улс гүрнүүд, олон улсын байгууллагуудаас олгосон зээл тусламжийн хагасаас илүү хувийг Япон улс дангаараа олгосон юм. Энэ хугацаанд Япон нь Монголд 1,2 тэрбум

гаруй ам.долларын зээл, буцалтгүй тусламж олгоод байна. Түүнчлэн 1990-ээд онд Их 8-ын орнуудаас Японы Ерөнхий сайд Монгол Улсад хоёр ч удаа айлчилж, хоёр орны хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргав. Шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт энэ харилцааг цаашид ч улам өргөтгөн хөгжүүлэх тухай заасан.

Европын орнуудтай харилцах явдал манай хамтын ажиллагаанд мөн л чухал байр суурь эзэлдэг. Европын холбоотой тогтоосон харилцааг гүнзгийрүүлэх, түүний гишүүн орнуудтай хоёр талын харилцааг шинэ агуулгаар баяжуулах, АЛА хөтөлбөрийн хүрээнд цаашид ч идэвхтэй ажиллах чиглэлийг бид баримталж байдаг. Энэ дашрамд дурдахад Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага Монгол Улсад хамтран ажиллах түншийн статусыг саяхан олгосон нь эгнээндээ 55 улсыг нэгтгэдэг Европын бүс нутгийн хамгийн том байгууллагын хүрээнд эдийн засаг, байгаль орчин болон шүүх засаглал, эрх зүйт төрийг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах салбарт мэдээлэл, туршлага харилцан солилцож, хамтран ажиллах шинэ боломжийг бүрдүүлсэн чухал алхам болов. Мөн энэ нь Монгол Улс НАТО-гийн Энхийн төлөө түншлэлд нэгдэхэд дөхөм болох учиртай.

Түүнчлэн Монгол Улсаас БНСУ, БНЭУ, АСЕАН-ны орнууд, Турк зэрэг улстай тогтоосон харилцаа, хамтын ажиллагаа идэвхитэй хөгжиж байгааг танай сэтгүүлийн уншигчид бэлээхнээ мэдэх бие ээ.

Манай иргэд хилийн чанадад чөлөөтэй зорчиж, тэнд олноор амьдрах, хөдөлмөрлөх эрхтэй. Эдүгээ хилийн чанадад бүдүүвчилсэн тоогоор манай 110 гаруй мянган иргэн амьдарч байна. Тэдний нэг хэсэг нь сурч, боловсрол эзэмшин эх орондоо оюуны хөрөнгө оруулалт хийж, нөгөө хэсэг нь ажиллаж амьдран эх орондоо мөнгөн гуйвуулга явуулж, ар гэр, ахан дүүсдээ тус дэм болж, Монгол Улсдаа бас нэг төрлийн хөрөнгө оруулалт хийж байгаа юм. Ийм ч учраас гадаадад байгаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах механизмыг боловсронгуй болгох, Консулын албыг бэхжүүлэх шаардлага байгаа тухай шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт зориуд тэмдэглэсэн байгаа. Энэ талаар Гадаад хэргийн яам дотроо зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ аваад байна. Тухайлбал, өмнө нь Эрх зүй, консулын газар дотор Консулын хэлтэстэй байсныг бүтэцийн өөрчлөлтөөр өргөтгөн биеэ даасан Консулын газартай болов. Энэ нь гадаадад байгаа мянга мянган иргэдийнхээ эрх ашгийг улам илүү идэвхтэй хамгаалахаар дэвшүүлж байгаа зорилтоо хэрэгжүүлэхээр бидний авч буй арга хэмжээний нэг

хэсэг нь юм. Цаашид гадаадад оршин суугаа Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хууль эрх зүйн акт, баримт бичгүүдийг шинэчлэх, шинээр байгууллахыг зорьж байна. Энэ чиглэлээр хийж буй ажлын талаар ард иргэддээ бид байнга мэдээлж байх болно.

Монголын түүх, соёл, өнөөгийн байдлыг гадаад ертөнцөд сурталчлах, Монголын тухай эерэг ойлголтыг бэхжүүлэх ажил бидний анхааралд онцгой байр суурь эзлэх болно. Монгол Улсын гадаад харилцааны түүх, уламжлалыг харуулсан цуврал баримтат кино хийх, ном гаргах зэргээр гадаад сурталчилгаанд ихээхэн анхаарна. Гадаад сурталчилгаатай холбогдуулан манай төрийн байгууллагууд болон хувийн хэвшлийнхний хоорондын хамтын ажиллагаа их чухал байгааг тэмдэглэж хэлмээр байна. Ардчилал, зах зээлийн эдийн засаг хир гүнзгий үр үндэстэй болж, иргэний нийгэм хэрхэн тууштай төлөвшиж байгаагаар нь манай орны дүр төрхийг гадаад ертөнцөд үнэлж дүгнэж байна. Чухамхүү эдгээр өөрчлөлтийг гадаадад таниулахад гадаад сурталчилгаа чиглэх ёстой.

Соёлын гадаад харилцаа өдгөө зогсонги байдалд байгаа нь мэдээжээр хөрөнгө мөнгөтэй холбоотой боловч соёлын харилцаа дипломат үйл ажиллагааны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг байсаар ирсэн цаашид ч байх болно. Иймд бид энэ талаар оновчтой бөгөөд тодорхой ажлыг хэрэгжүүлэхээр бодож төлөвлөж байна.

Дипломат албыг төрийн мэргэшсэн тусгай албын нь хувьд эрх зүй, эдийн засаг, нийгмийн хамгааллын чиглэлээр бэхжүүлж, мэргэжлийн ур чадвар, гадаад хэлний өндөр мэдлэгтэй боловсон хүчнээр хуулийн хүрээнд сэлбэх зорилтыг тууштай хэрэгжүүлэх бодлогыг Засгийн газар баримталж байна. Энэ чиглэлээр давын өмнө хийх ёстой ажил бол “Дипломат албаны тухай хууль”-ийн гол заалт, зарчмуудыг цаашид хэрэгжүүлэн ажил хэрэг болгохын сацуу уг хуулийн зарим зүйлийг нь эргэн харж, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах замаар дипломатуудын ажиллаж амьдрах нөхцлийг сайжруулах, уг хуулийн зарим заалтыг тэдний ажил, амьдралд ойртуулах явдал юм. Дипломат албыг олон талын мэдлэг боловсролтой, ёс суртахуунтай, эх оронч үзэлтэй, өөрийн орны түүх, уламжлал, соёл, зан заншлыг арван хуруу шигээ мэддэг, шинэ залуу боловсон хүчнээр бэхжүүлэх, үүний зэрэгцээ үе үеийн дипломатуудын баялаг туршлага амьдралын ухааныг залуусын эрч хүчтэй хослуулж, дипломат албаны залгамж чанарыг хангах явдал өнөөдөр юу юунаас чухал болоод байгаа юм. Энэ шаардлагыг харгалзан бид шат дараалсан арга хэмжээ авахаар бодож байна.

Гадаад бодлогын шийдвэр гаргалт нь өөрөө олон тооны гишгүүр шат, хөшүүргийн нийлбэрээс бүрддэг мэргэжлийн нарийн технологи, ур чадвар, арга зүй, мэдлэгийг шаарддаг ажил. Эдгээрийг бүрдүүлэхэд судалгааны ажил нэн чухал байдаг. Гадаад бодлогын аливаа шийдвэр гагцхүү үндэслэл сайтай судалгаанд тулгуурлаж байж гэмээж үнэн зөв, бодитой болдог. Ийм хэрэгцээ шаардлагыг харгалзан бид яамны дэргэд эрдэм шинжилгээ, судалгааны бие даасан төв байгуулах зорилт тавин ажиллаж байна.

Засгийн газар ард түмнийхээ итгэлийг биелүүлж, мөрийн хөтөлбөртөө тусгасан гадаад бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд өөрөөсөө хамаарах бүхнийг хийх болно.